ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/12/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Ахлах аудитор: Н.Туяа
Утас: 99799709

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

CONTENTS


**1 Аудитын гэрчилгээ** ..... 3

**2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан** ..... 4

**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан** ..... 4

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан** ..... 5

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан** ..... 6

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** ..... 8

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** ..... 9

**4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан** ..... 12

**3. Аудитын тайлан** ..... 14

**3.1. Оршил** ..... 14

**3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй** ..... 14

**3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт** ..... 14

**3.4 Материаллаг байдал** ..... 15

**3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт** ..... 15

**3.5.1 Мөнгөн хөрөнгө** ..... 15

**3.5.2 Авлага** ..... 15

**3.5.3 Бараа материал** ..... 16

**3.5.4 Үндсэн хөрөнгө** ..... 17

**3.5.5 Өр төлбөр** ..... 18

**3.5.6 Засгийн газрын хувь оролцоо** ..... 18

**3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга** ..... 19

**3.7 Шилэн дансны мэдээлэл** ..... 22

**3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн** ..... 23

**3.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал** ..... 24

**4. Менежментийн захидал** ..... 24

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт** ..... 26

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| БОАЖГ | Байгаль орчин аялал жуулчлалын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.04.19 № 400

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.МӨНХ-ОД ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хэнтий аймгийн Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

0230

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **714,440.90** | **952,732.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3а, 3б | **89,182.20** | **262,559.00** |
| **33** | **АВЛАГА** | 5а, 5б, 6а, 6б | **321,600.90** | **307,776.10** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8а, 8б, 8в | **303,657.70** | **382,397.00** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **7,582,166.90** | **7,464,347.00** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 12а, 12б, 12в | **7,582,166.90** | **7,464,347.00** |
| **39200** | **Биет хөрөнгө** | | **6,847,082.90** | **6,729,523.00** |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 13 | **735,084.00** | **734,824.00** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **8,296,607.80** | **8,417,079.10** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **0** | **10,612.60** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15а, 15б | **0** | **10,612.60** |
| **41300** | **Өглөг** | 17а, 17б | **0** | **10,612.60** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **8,296,607.80** | **8,406,466.40** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **8,296,607.80** | **8,406,466.40** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 3,396,584.70 | 3,396,584.70 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | | **4,642,718.20** | **4,752,576.90** |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 257,304.80 | 257,304.80 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **8,296,607.80** | **8,417,079.10** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 6,714,355.90 | 3,518,181.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 160,614.20 | 222,923.90 |
| 110 | Орлогын албан татвар | | 82,540.50 | 68,751.30 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 82,540.50 | 68,751.30 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 2,520.00 | 48,199.20 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 75,553.70 | 105,973.30 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 4,102,868.90 | 289,028.30 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 4,102,868.90 | 289,028.30 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 2,450,872.80 | 3,006,228.90 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 2,693,854.90 | 3,279,611.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 2,693,854.90 | 3,279,611.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 2,589,988.30 | 3,150,156.90 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,605,168.30 | 1,707,918.60 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 203,640.00 | 223,488.70 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 153,659.80 | 278,895.40 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 99,410.90 | 140,143.00 |
| 2105 | Нормативт зардал | | 94,464.40 | 170,093.80 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 10,183.60 | 19,687.20 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 9,052.00 | 12,140.40 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 97,162.70 | 88,452.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 317,246.50 | 509,337.70 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 103,866.70 | 129,454.60 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 4,020,501.00 | 238,569.60 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 106,027.50 | 128,960.90 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | | 3,914,473.50 | 109,608.70 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | | 2,720,397.90 | 3,328,001.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 160,614.20 | 222,923.90 |
| 110 | Орлогын албан татвар | | 82,540.50 | 68,751.30 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 82,540.50 | 68,751.30 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 2,520.00 | 48,199.20 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 75,553.70 | 105,973.30 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 21,194.00 | 25,985.50 |
| 1181 | Газрын төлбөр | | 5,621.90 | 3,885.10 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | 48,737.80 | 76,102.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 108,910.90 | 146,596.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 108,910.90 | 146,596.40 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 2,450,872.80 | 2,958,480.80 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 2,460,500.10 | 2,892,675.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 2,460,500.10 | 2,892,675.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 2,351,014.60 | 2,757,770.70 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,592,903.10 | 1,698,731.50 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 201,991.80 | 222,063.20 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 154,314.10 | 268,128.10 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 119,207.50 | 125,914.80 |
| 2105 | Нормативт зардал | | 72,596.10 | 170,022.40 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 36,671.10 | 40,837.20 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 9,052.00 | 12,110.40 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 114,801.60 | 119,164.50 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 49,477.20 | 100,798.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 109,485.50 | 134,905.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | | 259,897.80 | 435,325.30 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | | 153,734.50 | 197,948.60 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 153,734.50 | 197,948.60 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **153,734.50** | **197,948.60** |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | | **-153,734.50** | **-197,948.60** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | | **-109,000.00** | **-64,000.00** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | | **109,000.00** | **64,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | | **-2,836.70** | **173,376.70** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 92,019.00 | 89,182.20 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 89,182.20 | 262,559.00 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл** | **4,381,727.20** | **0** | **4,381,727.20** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **407.1** | **0** | **407.1** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,382,134.30** | **0** | **4,382,134.30** |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0** | **0** | **0** |
| 5 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **0** | **0** | **0** |
| 6 | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0** | **0** | **0** |
| 7 | **Өмчид гарсан өөрчлөлт** | **0** | **0** | **0** |
| 8 | **Зарласан ногдол ашиг** | **0** | **0** | **0** |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | **3,914,473.50** | **0** | **3,914,473.50** |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл** | **8,296,607.80** | **0** | **8,296,607.80** |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-ээр үлдэгдэл** | **8,296,607.80** | **0** | **8,296,607.80** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **8,296,607.80** | **0** | **8,296,607.80** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | 0 | 0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0 | 0 | 0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 109,608.70 | 0 | 109,608.70 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл** | **8,406,466.40** | **0** | **8,406,466.40** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,060,417.1** | **2,873,042.9** | **187,374.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,832,969.3** | **2,688,595.1** | **144,374.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,771,745.2** | **2,628,675.4** | **143,069.8** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,699,867.1** | **1,684,860.9** | **15,006.2** |
| 210101 | Үндсэн цалин | 1,081,005.2 | 1,140,499.8 | -59,494.6 |
| 210102 | Нэмэгдэл | 436,267.1 | 391,055.4 | 45,211.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,751.0 | 8,078.0 | 1,673.0 |
| 210104 | Урамшуулал | 111,171.2 | 97,411.5 | 13,759.7 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 61,672.6 | 47,816.2 | 13,856.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **233,127.0** | **220,530.4** | **12,596.6** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 164,919.4 | 153,235.7 | 11,683.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,051.9 | 17,012.5 | 39.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,641.6 | 13,507.7 | 133.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,410.4 | 3,350.1 | 60.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,103.7 | 33,424.3 | 679.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **342,939.2** | **265,028.1** | **77,911.1** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,263.7 | 28,725.1 | 2,538.6 |
| 210302 | Түлш, халаалт | 309,408.8 | 235,383.0 | 74,025.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,266.7 | 920.0 | 1,346.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **99,034.8** | **98,419.1** | **615.7** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,000.5 | 9,305.4 | -1,304.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 41,622.1 | 41,584.7 | 37.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,159.7 | 4,658.7 | 2,501.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 699.5 | 438.3 | 261.2 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,665.9 | 3,135.1 | -469.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 38,887.1 | 39,296.9 | -409.8 |
| **2105** | **Нормативт зардал** | **142,383.6** | **106,938.8** | **35,444.8** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,435.0 | 30,412.9 | 22.1 |
| 210502 | Хоол, хүнс | 106,543.0 | 71,318.8 | 35,224.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,405.6 | 5,207.1 | 198.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **73,051.1** | **73,038.0** | **13.1** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 46,460.0 | 46,459.8 | 0.2 |
| 210604 | Урсгал засвар | 26,591.1 | 26,578.2 | 12.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,475.7** | **11,394.9** | **80.8** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,475.7 | 11,394.9 | 80.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **69,722.9** | **68,832.8** | **890.1** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 59,196.6 | 58,401.2 | 795.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,204.0 | 3,204.0 | 0.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,343.5 | 1,331.6 | 11.9 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 519.4 | 436.7 | 82.7 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132.0 | 132.0 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,200.0 | 4,200.0 | 0.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,127.4 | 1,127.3 | 0.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **100,143.8** | **99,632.4** | **511.4** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 79,998.5 | 79,587.5 | 411.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,145.3 | 20,044.9 | 100.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,224.1** | **59,919.8** | **1,304.4** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **61,224.1** | **59,919.8** | **1,304.4** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,003.2 | 29,706.7 | 1,296.6 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,644.1 | 19,644.1 | 0.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,576.8 | 10,569.0 | 7.8 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **120,447.8** | **120,447.8** | |
| 223001 | Бусад хөрөнгө | 120,447.8 | 120,447.8 | |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **107,000.0** | **64,000.0** | **43,000.0** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 107,000.0 | 64,000.0 | 43,000.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,060,417.1** | **2,936,680.4** | **123,736.7** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,776,605.3** | **1,727,320.1** | **49,285.2** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 0.0 | 0.0 | 0.0 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,776,605.3 | 1,727,320.1 | 49,285.2 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,122,067.2** | **1,060,444.2** | **61,623.0** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,002,188.4 | 940,565.4 | 61,623.0 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 119,878.8 | 119,878.8 | |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **30,231.2** | **30,231.2** | |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 30,231.2 | 30,231.2 | |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **131,513.4** | **118,684.9** | **12,828.5** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 95,506.4 | 100,563.8 | -5,057.4 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,999.0 | 18,121.1 | -2,122.1 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 20,008.0 | 0.0 | 20,008.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 20,500.9 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 84,138.4 | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1112** | **1083** | **29** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **9** | **9** | |
| 610001 | Төсвийн байгууллага | 9 | 9 | |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0 | 0 | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **137** | **134** | **3** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 12 | 12 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 84 | 80 | 4 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 37 | 38 | -1 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 4 | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **829** | **806** | **23** |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **633** | **611** | **22** |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 633 | 611 | 22 |
| 630002 | Хувийн ЕБС | 0 | 0 | 0 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | **196** | **195** | **1** |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 196 | 195 | 1 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **137** | **134** | **3** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10 | 9 | 1 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 58 | 54 | 4 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 5 | 4 | 1 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 16 | 14 | 2 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 42 | 47 | -5 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6 | 6 | |

### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **232,296.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **203,908.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **178,208.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **13,870.63** |
| 210102 | Нэмэгдэл | 1,639.10 |
| 210104 | Урамшуулал | 12,231.54 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,532.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,008.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 141.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 110.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 24.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 248.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **3,100.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,553.75** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,203.18 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,800.71 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 420.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,773.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,356.66 |
| **2105** | **Нормативт зардал** | **63,083.58** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,860.98 |
| 210502 | Хоол, хүнс | 200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 22.60 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,434.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 555.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,879.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **715.50** |
| 210701 | Гадаад албан томилолт | 0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 715.50 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **50,331.71** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,331.71 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,586.21** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 540.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,046.01 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **25,700.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **25,700.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 25,700.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **28,388.03** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **28,388.03** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 28,388.03 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **232,296.17** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **232,296.17** |

| | | |
|---|---|---|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,208.80 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 189,450.47 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 41,636.90 |

# 3. Аудитын тайлан

## 3.1. Оршил

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Мөнх-Од танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналыг боловсронгуй болгох, авлагыг барагдуулах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 15 -аас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа хариуцаж гүйцэтгэв.

Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 1/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төсвийн тухай хуульд “төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 5.4.-д Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дадал сумын Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 онд дотоод аудит, хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд 2020 оны үр дүнгийн тайлангаас нийт зардлын дүн 3,514.4 сая төгрөгийн 1 хувь буюу 35.1 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг тогтоож, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 34.1 сая төгрөгөөр тооцож, дахин тодорхойлов. Үүссэн 1.0 сая төгрөгийн зөрүү нь бараа үйлчилгээний зардал буурсантай холбоотой байна.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 89.2 сая, эцсийн үлдэгдэл 262.5 сая төгрөг болж, 173.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 0 | 0 | 0 | 0 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 89.2 | 257.6 | 168.4 | 94 |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | 0 | 4.9 | 4.9 | 0.6 |
| Хадгаламж | 0 | 0 | 0 | 0 |
| **Дүн** | **89.2** | **262.5** | **173.3** | **100** |

Эх сурвалж: *Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 178.2 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 32.2 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 45.8 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангийн 2.4 сая төгрөг, Байгаль хамгаалах сангийн 2.5 сая төгрөг,ЭМТ-ийн 1.2 сая төгрөг, нийт 262.5 сая төгрөг байна. Үүнээс 257.6 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж, 4.9 сая төгрөгийн замд яваа мөнгө байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 227.4 сая, эцсийн үлдэгдэл 271.5 сая төгрөг болж, 44.1 сая

төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+) Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | - | - | - |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 53.8 | 53.8 |
| Татаас, санхүүжилтийн авлага | - | - | - |
| Зээлийн хүүгийн авлага | - | - | - |
| Дансны авлага /ТӨҮГ/ | - | - | - |
| Бусад авлага | 36.8 | - | (36.8) |
| Зээлийн авлага | 284.8 | 254.0 | (30.8) |
| **Дүн** | **321.6** | **307.8** | **(13.8)** |

*Эх сурвалж: Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас олгосон зээлийн авлага 60.2 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага 193.8 сая төгрөг, Эрүүл мэндийн төв Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтийн 53.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас олгосон зээлийн авлага өмнөх оноос 39.4 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 303.6 сая, эцсийн үлдэгдэл 382.4 сая төгрөг болж, 78.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 3. Бараа материалын үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+) Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | **9.5** | **32.7** | **23.2** |
| Тусгай зориулалттай материал | 0.9 | 6.1 | 5.2 |
| Эм боох материал | 8.6 | 20.9 | 12.3 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | | 5.7 | 5.7 |
| **Хангамжийн материал** | **291.9** | **347.5** | **55.6** |
| Бичиг хэргийн материал | 4.7 | 4.2 | -0.5 |
| Аж ахуйн материал | 237.8 | 302.0 | 64.2 |
| Сэлбэг хэрэгсэл | 9.7 | 14.3 | 4.6 |
| Түлш, шатах тослох материал | 12.2 | 1.5 | -10.7 |
| Барилгын засварын материал | | | 0.0 |
| Хүнсний материал | 3.5 | 15.6 | 12.1 |
| Бусад хангамжийн материал | 24.0 | 9.9 | -14.1 |
| **Мал амьтад** | **2.2** | **2.2** | **0.0** |
| **Дүн** | **303.6** | **382.4** | **78.8** |

*Эх сурвалж: Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд 594.3 сая төгрөгийн бараа материалыг орлого авснаас 557.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 37.3 сая төгрөгийн бараа материалыг хандиваар болон шилжүүлэн авсан байна. Нийт 515.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

***Аудитын илрүүлэлт:***

1. *Сумын ЗДТГ худалдан авсан 12,827.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.*
2. *Цэцэрлэг хүнсний материалын жилийн эцсийн тооллогоор биетээр байгаа гэж бүртгэлд тусгасан болович үлдэгдлийн хяналтын тооллогоор 203.0 мянган төгрөгийн үнэ бүхий 20,3 кг үхрийн мах дутагдуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.*
3. *Соёлын төвийн бараа материалын үлдэгдлээс хөрөнгийг түүвэрлэн тооллого хийхэд 8680.0 мянган төгрөгийн барилгын засварын материалыг зарцуулсан болович үлдэгдлээр илэрхийлж нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.*

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,582.2 сая, эцсийн үлдэгдэл 7,464.3 сая төгрөг болж, 117.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **6,847.1** | **6,729.5** | **-117.6** |
| Барилга, байгууламж, орон сууц | 5,604.1 | 5,496.0 | -108.1 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 285.6 | 257.2 | -28.4 |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 706.5 | 719.6 | 13.1 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 159.4 | 173.5 | 14.1 |
| Зам, гүүрний байгууламж | | | |
| Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | | | |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 61.1 | 61.1 | |
| Бусад үндсэн хөрөнгө | 5.5 | 0 | -5.5 |
| Дуусаагүй барилга, байгууламж | | | |
| Ном | 24.9 | 22.1 | -2.8 |
| **Биет бус хөрөнгө** | **735.1** | **734.8** | **-0.3** |
| Программ хангамж | 1 | 0.7 | -0.3 |
| Бусад биет бус хөрөнгө | 734.1 | 734.1 | |
| **Дүн** | **7,582.2** | **7,464.3** | **-117.9** |

Эх сурвалж: *Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 77.5 сая, үнэ төлбөргүйгээр авсан 226.5 сая төгрөгийн, нийт 304.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авсантай холбоотой байна.

Тайлант онд 116.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасан, 5.7 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

***Аудитын илрүүлэлт:***

*Аудитаар илэрсэн дараах алдаа зөрчлүүдийг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:*

1. *Сумын ЗДТГ худалдан авсан 17,172.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн.*
2. *Сумын ЗДТГ БОАЖГ-аас мод үржүүлгийн газарт олгосон 30,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг орлогоор бүртгэсэн, мөн орон*

*нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан сумын төвийн зам засварын 9,947.8 мянган төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөд бүртгэж, зарлагдсан.*

3. *Цэцэрлэг худалдан авсан 5.7 сая төгрөгийн номыг үндсэн хөрөнгийн дансанд ангилал зөрүүлэн бүртгэсэн.*

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 10.6 сая төгрөг болж, 10.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл* */сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Өглөг** | **-** | **10.6** | **10.6** |
| Ажиллагсадтай холбогдсон өглөг | | 10.6 | 10.6 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | | | - |
| **Бусад өглөг** | **-** | **-** | **-** |
| **Нийт дүн** | **-** | **10.6** | **10.6** |

*Эх сурвалж: Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ЭМТ-ийн ажиллагсдад төлөх 10.6 сая төгрөгийн цалин урамшууллын өглөгтэй байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 8,296.6 сая, эцсийн үлдэгдэл 8,406.5 сая төгрөг болж, 109.9 сая төгрөгөөр өссөн байна.

**ХҮСНЭГТ № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО** **/САЯ ТӨГРӨГ/**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **3,396.6** | **3,396.6** | **0.0** | **42.8** |
| **Хуримтлагдсан үр дүн:** | **4,642.7** | **4,752.6** | **109.9** | **36.0** |
| Өмнөх үеийн үр дүн | 728.2 | 4,643.0 | 3,914.8 | |
| Тайлант үеийн үр дүн | 3914.5 | 109.6 | -3,804.9 | |
| **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | **257.3** | **257.3** | **0.0** | **21.2** |
| **Дүн** | **8,296.6** | **8,406.5** | **109.9** | **100** |

*Эх сурвалж: : Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Орлогын данс

Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь 3,518.2 сая төгрөгийн орлогоос татварын орлого 222.9 сая төгрөг, татварын бус орлого 289.0 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 3,006.2 сая төгрөг байна.

Татварын бус орлогод төсөвт байгууллагын туслах үйл ажиллагаанаас 18.1 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 239.8 сая төгрөг, зээлийн хүүгийн 3.1 сая төгрөгийн орлого байна. Үүнд: Байгаль хамгаалах сан 17.6 сая, Засаг даргын Тамгын газар 136.1 сая, Соёлын төв

10.0 сая, ЕБС 16.2 сая, Сум хөгжүүлэх сан 5.7 сая, Эрүүл мэндийн төв 57.4 сая төгрөг, Цэцэрлэг 18.1 сая төгрөгийн орлого хүлээн авсан байна.

### 3.5.8 Зардлын данс

Үйл ажиллагааны нийт зардал 3,279.6 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 129.0 сая төгрөг байна. Үйл ажиллагааны бус зардал нь үндсэн хөрөнгийг данснаас хассан болон ОНХС-ийн хөрөнгийн зардалтай холбоотой байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дадал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолд заасанаар төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 134.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 250.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 116.8 сая төгрөгөөр давуулан буюу 187.1 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 8.* Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

| № | Орлогын нэр төрөл | 2021 он | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | Аж ахуй эрхэлсний орлого | 15,000.0 | 9,545.8 | (5,454.2) | 63.6 |
| 2 | БОНАТатвар | 300.0 | - | (300.0) | - |
| 3 | Хөрөнгийн орлого | 35,000.0 | 50,662.3 | 15,662.3 | 144.7 |
| 4 | ҮХХБ орлого /2%/ | 600.0 | 8,543.2 | 7,943.2 | 1,423.9 |
| 5 | Галт зэвсгийн албан татвар | 2,700.0 | 2,850.0 | 150.0 | 105.6 |
| 6 | Улсын тэмдэгтийн хураамж | 4,500.0 | 5,393.5 | 893.5 | 119.9 |
| 7 | Газрын төлбөр | 6,307.0 | 3,885.1 | (2,421.9) | 61.6 |
| 8 | Ойн нөөц ашигласны төлбөр | 36,630.8 | 74,062.8 | 37,432.0 | 202.2 |
| 9 | Агнуурын нөөц ашигласны төлбөр | 3,000.0 | 2,039.9 | (960.1) | 68.0 |
| 10 | ТТАМ -ын нөөц ашигласны төлбөр | 4,000.0 | 10,912.6 | 6,912.6 | 272.8 |
| 11 | Хог хаягдлын хураамж | 10,000.0 | 9,679.4 | (320.6) | 96.8 |
| 12 | Малын албан татвар | - | 45,349.2 | 45,349.2 | |
| 13 | Татварын хүү торгууль | 8,000.0 | 16,256.5 | 8,256.5 | 203.2 |
| 14 | Татварын бусад орлого | 8,000.0 | 11,655.0 | 3,655.0 | 145.7 |
| | **Нийт дүн** | **134,037.8** | **250,835.4** | **116,797.6** | **187.1** |

Сумын төсвийн орлогын биелэлтийг орлогын төрлөөр авч үзвэл хөрөнгийн орлого хөрөнгө борлуулсны орлого, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хүү торгуулийн орлого, малын албан татварууд давж биелсэн нь орлогын төлөвлөлттэй холбоотой бол ойн нөөц ашигласны төлбөрийн орлого Онон Балжийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргааны талбай тусгаарласан гоожингийн төлбөр нэмэгдэж орсноос шалтгаалан давж биелжээ.

***Аудитын илрүүлэлт:***

- *Үйл ажиллагааны орлогыг 5454.2 мянган төгрөгөөр, газрын төлбөрийг 2421.9 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөрийг 960.1 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлогыг 320.6 мянган төгрөгөөр, нийт 9156.8 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.*

## Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-аас нийт зардал, эх үүсвэрийг 3,100.1 сая төгрөгөөр, тодотголоор 39.7 сая төгрөгөөр бууруулж нийт 3,060.4 сая төгрөгөөр баталсан байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 3,060.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,833.0 сая төгрөгийг урсгал зардалд, 120.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 107.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 799.5 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 799.5 сая төгрөгөөр олгожээ.

Нийт зардлын 1,776.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,002.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 119.9 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангаас, 30.2 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 111.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 20.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 1,776.6 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт 1,002.2 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох 119.9 сая төгрөгийг, Эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох 30.2 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн байна. ОНХС-д 31.7 сая төгрөгийн малын албан татварын орлогыг төвлөрүүлж, 13,617.9 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогод 100.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 5.0 сая төгрөгөөр давсан нь батлагдсан орлогын төлөвлөгөөг Жижиг дунд бизнесийг дэмжих сан 13.3 сая төгрөгөөр илүү, Сум хөгжүүлэх сан 8.2 сая төгрөгөөр дутуу биелүүлснээс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 18.1 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 2.1 сая төгрөгөөр давсан нь Байгаль хамгаалах сан орлогыг давуулж биелүүлснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,873.0 сая төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь эргэж төлөгдөх зээл 43.0 сая төгрөг, бараа ажил үйлчилгээний зардал 143.0 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 1.3 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна. Үүнд:

Урсгал зардлын гүйцэтгэлийг авч үзвэл цалин хөлс болон нэмэгдэл урамшил 15.0 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 12.6 сая төгрөгөөр, байр ашиглалтын тогтмол зардал 77.9 сая төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардал 0.6 сая төгрөгөөр, хоол хүнс, нормативт зардлыг 35.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 0.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 0.5 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 93.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлснийг авч үзвэл Засаг даргын тамгын газар 62.1 сая төгрөгийг, Соёлын төв 29.0 сая төгрөгийг, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 0.6 сая төгрөгийг, Эрүүл мэндийн төв 0.1 сая төгрөгийг, Ерөнхий боловсролын сургууль 0.01 сая төгрөгийг, Цэцэрлэг 1.5 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Мөн тусгай зориулалтын шилжүүлгийн үлдэгдлээс Хүүхдийн цэцэрлэг 30.5 сая төгрөгийг, Ерөнхий боловсролын сургууль 18.8 сая төгрөгийг төгрөгийг, нийт 49.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Орон нутгийн хөгжлийн сангаар 120.4 сая төгрөгийн 7 ажил хийгдэхээр төлөвлөж ажлыг 120.4 сая төгрөгөөр бүрэн гүйцэтгүүлсэн байна.

Эргэж төлөгдөх зээл 43.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас олгох 32.5 сая төгрөгийн, Сум хөгжүүлэх сангаас олгох 10.5 сая төгрөгийн зээлийг олгоогүйтэй холбоотой байна.

***Аудитын илрүүлэлт:***

1. *Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох зардлыг хэмнээгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан 15.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:*
   - *ЕБСургууль 7.5 сая төгрөг*
   - *Цэцэрлэг 3.8 сая төгрөг*
   - *Соёлын төв 3.9 сая төгрөг*
2. *Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 23.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:*
   - *Цэцэрлэг 0.7 сая төгрөг*
   - *Сум хөгжүүлэх сан 0.4 сая төгрөг*
   - *Байгаль хамгаалах сан 22.3 сая төгрөг*
3. *Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 7.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:*
   - *ЕБСургууль 7.5 сая төгрөг*
   - *Цэцэрлэг 0.2 сая төгрөг*
4. *Байгаль хамгаалах санд хууль тогтоомжид нийцээгүй 17.6 сая төгрөгийн орлого бүртгэсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.*
5. *Малын тоо толгойн албан татварыг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхдээ 13.617.9 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүлсэн.*

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансанд дээд шатны төсвийн захирагчаас 189,450.5 мянган төгрөгийн хөрөнгө, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 41,636.9 мянган төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 1,208.8 мянган төгрөгийн, нийт 232,296.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнд: Сумын ИТХ 4,800.0 мянган төгрөг, Засаг даргын тамгын газар 79,137.4 мянган төгрөгийн, Ерөнхий боловсролын сургууль

27,043.7 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төв 114,363.4 мянган төгрөгийн, Соёлын төв 6,450.0 мянган төгрөгийн, Цэцэрлэг 501.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшилд 13,870.6 мянган төгрөгийг, нийгмийн даатгалын шимтгэлд 1,532.8 мянган төгрөгийг, байр ашиглалттай холбоотой зардалд 3,100.0 мянган төгрөгийг, хангамжийн бараа материал худалдан авахад 28,553.7 мянган төгрөгийг, эм бэлдмэлийн зардалд 62,861.0 мянган төгрөгийг, хоол хүнсний зардалд 200.0 мянган төгрөгийг, зөөлөн эдлэлийн зардалд 22.6 мянган төгрөгийг, эд хогшил, урсгал засварын зардалд 12,434.0 мянган төгрөгийг, томилолтын зардалд 715.5 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 50,331.7 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,586.2 мянган төгрөгийг, шагнал урамшуулалд 25,700.0 мянган төгрөгийг зарцуулж, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 28,388.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

***Аудитын илрүүлэлт:***

- ***Сумын ЗДТГ нэмэлт дансанд Онон голын гүүрний хураамжийн орлого 5,151.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.***

**3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагч шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 335,146.3 мянган төгрөгийн 55 мэдээллийг 100 хувь мэдээлсэн байна.

ЕБС таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад орлого, зарлагын мөнгөн гүйлгээ дутуу мэдээлсэн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

**3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 22.5 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | | | | | | | |
| Албан шаардлага | 1 | 1.7 | 1 | 1.7 | | | 100 |
| Зөвлөмж | 1 | 22.5 | 1 | 22.5 | | | 100 |
| **Нийт** | **2** | **24.2** | **2** | **24.2** | | | **100** |

Сум хөгжүүлэх санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг 90 хувьтай, Жижиг дунд бизнесийг дэмжих сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бууруулах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 төрийн сангийн, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 тусгайн сангийн нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 төсвийн байгууллага, 1 төрийн сан аудит хийж дүгнэлт гарган, Жижиг дунд бизнесийг дэмжих сан, Байгаль хамгаалах сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангууд аудитын түүвэрт хамрагдсан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллага Цэцэрлэгийн санхүүгийн тайланд “Өндөрхаан Итгэл аудит “ ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

“Эмийн эргэлтийн сан” орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй нь цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалсан болно.

*Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 398.8 сая төгрөгийн 13 алдаа, зөрчил илрүүлснээс 75.6 сая төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 7.9 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 315.3 сая төгрөгийн 7 зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.*

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүгүй нэгтгэсэн байна. Харьяа байгууллагын үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг нэгтгэхдээ төсөвт байгууллагуудад олгосон урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн 1,033.9 сая төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 93.4 сая төгрөг, нийт 1,127.3 сая төгрөгийг устгах бичилтийг хийж тайланг нэгтгэсэн байна.

***<u>Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага</u>***

1. Дадал сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 439.0 мянган төгрөгийг шагналд зарцуулсан нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.8.-т *“Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн</u>:** Зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Төвлөрүүлсэн захирагчид 62.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

*Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 63.0 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илрүүлснээс 0.4 сая төгрөгийн 1 зөрчлийг дахин давтахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 62.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүллээ.*

### 3.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлэхдээ Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан заавар журмын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгыг бүрэн бэлтгэн ирүүлсэн эсэх, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзнэ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1. Орлогын данстай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:* Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзэхэд үйл ажиллагааны орлогыг 5454.2 мянган төгрөгөөр, газрын төлбөрийг 2421.9 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөрийг 960.1 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлогыг 320.6 мянган төгрөгөөр, нийт 9156.8 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;” заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

*1.2. Эрсдэл:* Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлээгүй байх.

*1.3. Өгсөн зөвлөмж:* Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:* Байгаль хамгаалах санд хууль тогтоомжид нийцээгүй 17,612.1 мянган төгрөгийн орлого бүртгэсэн нь "Ашигт малтмалын тухай" хуулийн 38.1.8-д дахь заалтад нийцэхгүй байна.

*2.2. Эрсдэл:* Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Байгаль хамгаалах санд "Ашигт малтмалын тухай" хуулийн 38.1.8-д заасанаас өөр орлого төвлөрүүлэхгүй байх

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

***3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт* : Байгаль хамгаалах сангаас 22,344.2 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь "Ашигт малтмалын тухай" хуулийн 38.3, 38.4 дэх заалтад нийцэхгүй байна.

*3.2. Эрсдэл:* Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

*3.3. Өгсөн зөвлөмж:* Байгаль хамгаалах сангаас "Ашигт малтмалын тухай" хуулийн 38.3, 38.4-д зааснаас өөр зардал гаргахгүй байх

*3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

**4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

*4.1. Илрүүлэлт:* Малын тоо толгойн албан татварыг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхдээ 13,617.9 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

*4.2. Эрсдэл:* Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байх

*4.3. Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 60.2. “Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.8. малын тоо толгойн албан татварын орлого” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж татварын орлогыг Орон нутгийн хөгжлийн санд бүрэн төвлөрүүлж ажиллах.

*4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

| | | | |
|---|---|---|---|
| **Огноо:** 2022.03.25 | **Аудитын нэр:** | Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | **Аудитын код:** ХЭА-2022/17/СТА-ТТ3 |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | | Дадал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч | **сая төгрөгөөр** |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Худалдан авсан 17,172.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 12,827.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн. | 30.0 | Санхүүгийн тайланд залруулсан | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Гэрэлмаа С.Нандинцэцэг |
| 2 | БОАЖГ-аас мод үржүүлгийн газарт олгосон 30,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг орлогоор бүртгэсэн, орон нутгийн хөгжлийн сангийн сумын төвийн зам засварын 9,947.8 мянган төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөд бүртгэж, зарлагдсан. | 39.9 | Санхүүгийн тайланд залруулсан | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Гэрэлмаа С.Нандинцэцэг |
| 3 | Нэмэлт дансанд Онон голын гүүрний хураамжийн орлого 5,151.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. | 5.1 | Албан шаардлага өгсөн | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Гэрэлмаа С.Нандинцэцэг |
| | **ЗДТГ-ын зөрчлийн дүн** | **75.0** | | | |
| 1 | Жилийн эцэст 7.5 сая төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч, үндэслэлгүй зарцуулсан. | 7.5 | Төлбөрийн акт тогтоосон | ЕБС-ийн захирал, Нягтлан бодогч | Д.Дамдинпүрэв А.Анар |
| 2 | Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллыг зөрчин 7.5 сая төгрөг зарцуулсан. | 7.5 | Албан шаардлага өгсөн | ЕБС-ийн захирал, Нягтлан бодогч | Д.Дамдинпүрэв А.Анар |
| 3 | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад орлого, зарлагын мөнгөн гүйлгээ дутуу мэдээлсэн. | 285.6 | Албан шаардлага өгсөн | ЕБС-ийн захирал, Нягтлан бодогч | Д.Дамдинпүрэв А.Анар |
| | **ЕБС-ийн зөрчлийн дүн** | **300.6** | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Худалдан авсан 5.7 сая төгрөгийн номыг үндсэн хөрөнгийн дансанд ангилал зөрүүлэн бүртгэсэн. | 5.7 | Санхүүгийн тайланд залруулсан | Цэцэрлэгийн нягтлан бодогч | А.Анар |
| 2 | Хүнсний материалын жилийн эцсийн тооллогоор биетээр байгаа гэж бүртгэлд тусгасан боловч үлдэгдлийн хяналтын тооллогоор 203.0 мянган төгрөгийн үнэ бүхий 20,3 кг үхрийн мах дутагдуулсан. | 0.2 | Төлбөрийн акт тогтоосон | Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч | Н.Одгарав А.Анар |
| 3 | 198,0 төгрөгийн 1 ш /Мөрийн хөтөлбөр/ ном худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан | 0.2 | Төлбөрийн акт тогтоосон | Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч | Н.Одгарав А.Анар |
| 4 | Хүүхдийн хоолны материалын зардлаас барилгын ажилчдад 732.5 мянган төгрөгийн хоол хийж өгч материалыг зориулалт бусаар зарцуулсан. | 0.7 | Албан шаардлага өгсөн | Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч | Н.Одгарав А.Анар |
| 5 | Үндсэн үйл ажиллагаатай холбоотой,зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлын хэмнэлтээс 1,060.0 мянган төгрөгийн албан конторын тавилга, 720.0 мянган төгрөгийн ажлын хувцас худалдан авч, 1,795.0 төгрөгийн сургалтын зардал, 207.0 төгрөгийн албан томилолтын зардал гаргасан. | 3.8 | Албан шаардлага өгсөн | Цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч | Н.Одгарав А.Анар |
| | **Цэцэрлэгийн зөрчлийн дүн** | **10.6** | | | |
| 1 | Батлагдсан урсгал зардлаас тэвчиж болох 3,909.8 мянган төгрөгийг хэмнэж ажиллаагүй. | 3.9 | Албан шаардлага өгсөн | Соёлын төвийн эрхлэгч, Нягтлан бодогч | Ш.Гангантуул Ж.Мөнхзул |
| 2 | Бараа материалын үлдэгдлээс хөрөнгийг түүвэрлэн тооллого хийхэд 8,680.0 мянган төгрөгийн барилгын засварын материалыг зарцуулсан боловч үлдэгдлээр илэрхийлж нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй байна. | 8.7 | Албан шаардлага өгсөн | Соёлын төвийн эрхлэгч, Нягтлан бодогч | Ш.Гангантуул Ж.Мөнхзул |
| | **Соёлын төвийн зөрчлийн дүн** | **12.6** | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хууль тогтоомжид нийцээгүй орлого бүртгэсэн. | 17.6 | Зөвлөмж өгсөн | Засаг дарга, Нягтлан бодогч | Д.Мөнх-Од Ж.Мөнхзул |
| 2 | Хууль тогтоомжид нийцээгүй зардал гаргасан. | 22.3 | Зөвлөмж өгсөн | Засаг дарга, Нягтлан бодогч | Д.Мөнх-Од Ж.Мөнхзул |
| | **Байгаль хамгаалах сангийн зөрчлийн дүн** | **39.9** | | | |
| 1 | Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 439.0 мянган төгрөгийг шагналд зарцуулсан. | 0.4 | Албан шаардлага өгсөн | Засаг дарга, Нягтлан бодогч | Д.Мөнх-Од Ж.Мөнхзул |
| | **Сум хөгжүүлэх сангийн зөрчлийн дүн** | **0.4** | | | |
| 1 | Үйл ажиллагааны орлогыг 5454.2 мянган төгрөгөөр, газрын төлбөрийг 2421.9 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөрийг 960.1 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлогыг 320.6 мянган төгрөгөөр, нийт 9156.8 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. | 9.1 | Зөвлөмж өгсөн | Засаг дарга, Санхүүгийн албаны дарга | Д.Мөнх-Од Д.Агаармандал |
| 2 | Малын тоо толгойн албан татварыг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхдээ 13.617.9 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн. | 13.6 | Зөвлөмж өгсөн | Засаг дарга, Санхүүгийн албаны дарга | Д.Мөнх-Од Д.Агаармандал |
| | **ТТЗ-ийн дүн** | **22.7** | | | |
| | **Нийт дүн** | **461.8** | | | |

# ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 15 Дугаар 230/A2370454 Чингис хот

ХЭА-2022/242/НА-СТА-Т1Ш3

**Зөрчил арилгах тухай**

"Төрийн аудитын тухай" хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дадал сумын Сум хөгжүүлэх хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан"-д хийсэн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дадал сумын СХС-ийн хөрөнгөөс шагналын зардалд 439,000.0 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.8.-т "Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Журамд заасан үндэслэлтэй нийцээгүй үйл ажиллагаанд сангаас хөрөнгө зарцуулсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 11 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дадал сумын Засаг дарга Д.Мөнх-Од-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

АУДИТОР Ц.ЭНХТҮВШИН

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9874952

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390